

ОЛОН НИЙТИЙН [САЙН] ОРОЛЦООГ ХАНГАХ ТУХАЙ ХУУЛЬ

1. Олон нийтийн оролцоо

- 1.1. Шийдвэр гаргах процесст ашиг сонирхол бүхий бүлэг болон олон нийтийг оролцуулахдаа төрийн эрх бүхий албан тушаалтнууд нь шийдвэрийн мөн чанар, хамгийн боломжит сайн чанартай байх зэргийг нягтална.
- 1.2. Энэ хуулийн зорилгыг хангах үүднээс “олон нийтийн оролцоо” гэдгийг шийдвэр гаргах процессын талаар олон нийт мөн ашиг сонирхол бүхий бүлэгт мэдээлэн, тэдэнтэй хэлэлцүүлэг хийн, зөвлөлдөх явдал гэж ойлгоно. “Мэдээлэх” гэж олон нийт болон ашиг сонирхол бүхий бүлгүүдэд гаргаж буй шийдвэрийг ойлгогдохоор байх, шийдвэр гаргахад байж болох бусад хувилбаруудыг оролцуулсан байх, шийдвэрийн үндсэн зорилгыг тодруулсан бодит, тэнцвэртэй мэдээллээр хангахыг хэлнэ. “Олон нийттэй зөвлөлдөх, хэлэлцүүлэг хийх” гэж бодлого тодорхойлох бүх шатны тэр дундаа асуудал дэвшүүлэх, зорилго тодорхойлох, бусад сонголтот хувилбаруудад дүн шинжилгээ хийх, төсөл боловсруулах зэрэг шатанд олон нийт болон ашиг сонирхол бүхий бүлгүүдээс санал авч сонсохыг хэлнэ.
- 1.3. Тодорхой ашиг сонирхол бүхий бүлгүүд болон нийгэмд бүхэлд нь нөлөөлөх бодлогын санаачлагыг боловсруулахад заавал олон нийтийн оролцоог байлгана. Тооцоолж буй нөлөөллийн хүрээ их байх тусам олон нийтийн оролцоог тэр хэмжээгээр их байлгах гэсэн үндсэн зарчим үйлчилнэ. Олон нийтийн оролцоог байлгах гэсэн хэрэгцээ шаардлага болон олон нийтийн оролцоог улам их болгох асуудлыг нөлөөллийн шинжилгээ хийж байх явцад тодорхойлно. Мөн ач холбогдол бүхий нөлөөтэй, эсхүл ашиг сонирхол байгаа гэж тооцоолж байгааа шийдвэрийн төсөл бэлтгэхэд олон нийтийн оролцоог хангана.
- 1.4. Riigikogu шатанд буюу Засгийн газар, сайд нарын түвшинд шийдвэр гаргах эсхүл хууль зүйн баримт бичиг боловсруулж бэлтгэхэд олон нийтийн оролцоо заавал байна. Олон нийтийн сайн оролцоог хангах тухай хууль нь Европын Холбооны асуудлаар засгийн газрын байр суурийг илтгэх асуудлыг бэлтгэхэд хэрэглэгдэнэ.

2. Ашиг сонирхол бүхий бүлгүүд болон олон нийтийн оролцоо

- 2.1. Нөлөөллийг Судлах Зааварчилгааны дагуу тухайн шийдвэрийн төсөлд нөлөөллийн үнэлгээг хийхдээ төрийн эрх бүхий байгууллага нь тодорхой ашиг сонирхол бүхий бүлгүүдэд болон нийгэмд бүхэлд нь нөлөөлнө гэж үзвэл олон нийтийн оролцоо байх ёстой цаг хугацаа, цар хүрээ, хэрэгцээг мөн тодорхойлон гаргана. Засгийн газраас баталсан Нөлөөллийг Судлах Зааварчилгааны дагуу нөлөөллийн үнэлгээ хийгдэнэ.
- 2.2. Тухайн шийдвэр нөлөөлж болох сонирхолын бүлгүүдийг төрийн эрх бүхий байгууллага тодорхойлно. Ашиг сонирхолыг бүлэг нь тухайн шийдвэр нөлөөлж болохуйц мөн тухайн шийдвэрийн хэрэгжилтэд оролцох, эсхүл тухайн асуудлаар өөрийн ашиг сонирхолыг маш тодорхой илэрхийлсэн хэд хэдэн хувь

хүнээс, хуулийн этгээд эсхүл албан бусаар нэгдсэн эвсэл холбоодоос бүрдэж болно.

2.3. Ашиг сонирхолын бүлгийн цар хүрээ нь олон нийтийн оролцоог хангах үеэр зохистойгоор өргөжин тэлж болно. Олон нийтийн оролцоо нь өргөжин тэлэхийнхээ хирээр ашиг сонирхолын бүлгүүдийн оролцооны цаг хугацаа, оролцооны хэлбэрээрээ өөр өөр байж болно.

3. Олон нийтийн оролцоог төлөвлөн бий болгох болон оролцох боломжийн талаар мэдээлэх нь

3.1. Сайд нар хэлэлцүүлэг зөвлөлгөөнд оролцох ашиг сонирхолын бүлгүүдийг, хуулийн төслийн эхний хувилбар бэлэн болох эцсийн хугацааг, боловсруулалтын бүхий л үе шатны хугацааг тогтооно. Төсөл боловсруулах ажлыг хариуцаж буй албан тушаалтны нэр, холбогдох хаягийг мэдээлнэ. Дээрх мэдээллүүдийн хамтаар хуулийн төслийг боловсруулах болсон санаачлага, стратегийн баримт бичиг боловсруулах саналыг мөн танилцуулна. Олон нийтийн оролцооны асуудлыг хариуцсан хэсэгтэй холбогдох хаягийн мэдээллийг яамдууд өөрсдийн цахим хуудсанд байршуулна.

4. Шийдвэр гаргах янз бүрийн түвшинд ашиг сонирхол бүхий бүлэглэл болон олон нийттэй хамтран ажиллах, тэдний оролцооны зорилгыг тайлбарлан өгөх

4.1. Төслийг боловсруулж байхдаа эрх бүхий төрийн байгууллага ашиг сонирхол бүхий бүлгүүд болон олон нийтийн оролцоог процесс ажиллагааны аль болох эхнээс нь хангах, боломжтой бол процесс ажиллагаанд бүхэлд нь оролцуулж хэлэлцүүлэг, зөвлөлдөөн өрнүүлнэ. Олон нийтийн оролцоо бүхий хэлэлцүүлэг зөвлөлдөөнийг процесс ажиллагааны явцад дор хаяж хоёр удаа: төслийг боловсруулахын тулд Мандат авах үед, мөн төслийг боловсруулж дууссан үед хийнэ.

4.2. Төрийн эрх бүхий байгууллага шийдвэр гаргахаас өмнө Хуулийн төслийн Мэдээллийн Системд хэвлэн нийтлэх замаар эсхүл хэрэв зохистой гэж үзвэл тодорхой ашиг сонирхолын бүлгүүдэд хандан шууд санал авч цуглуулах, эсхүл санал бодлоо илэрхийлэх замаар хуулийн төслийг боловсруулах болсон санаачлага, стратегийн баримт бичиг боловсруулах санал, эсхүл тухайн төсөлд хамаарах нөлөөллийн ач холбогдолтой гэж үзэж буй бусад асуудлыг танилцуулна.

4.3. Европын Холбоонд хамаарах асуудлаар олон нийтийн санаа бодлыг сонсох гэж байгаа бол эрх бүхий төрийн байгууллагаас Европын Комиссоос гаргасан санаачлагыг Эстони Улсын Засгийн газрын байр суурийн талаарх төсөл бичиг болон түүний тайлбарын хамтаар ашиг сонирхол бүхий бүлгүүдэд танилцуулна. Эрх бүхий байгууллагын зүгээс уг асуудлаар Европын Холбооны байгууллагуудын хооронд өрнөж байгаа хэлэлцүүлэгийн явц болон хэрэв уг асуудлаар Эстони Улсын Засгийн газрын байр суурь өөрчлөгдсөн бол уг өөрчлөлтийн талаар ашиг сонирхол бүхий бүлгүүдийг мэдээллээр хангана.

4.4. Хэрэв төсөлд нөлөөллийн үнэлгээн дэх дүн шинжилгээний тайланг хавсаргасан бол уг тайланг төслийн хамтаар олон нийтийн хэлэлцүүлэг зөвлөлдөөнд оруулна.

4.5. Төрийн эрх бүхий байгууллагын зүгээс олон нийтийн хэлэлцүүлэг зөвлөлдөөнийг нээж байгаа талаарх мэдээллийг ашиг сонирхолын бүлгүүдэд өгнө. Ашиг сонирхолын бүлгүүд болон олон нийтэд яагаад тухайн шийдвэрийн төсөл болвсруулах шаардлагатай болсон, олон нийт уг ажиллагаанд оролцохын гол зорилго нь юу болох, тэдгээрийн саналын хүрээ ямар байх, төслийг боловсруулах дараагийн үе шат ажиллагаанууд юу болох талаар тайлбарлана. Үүнд:

- Тодорхойлон хаягласан ашиг сонирхолын бүлгүүдэд хандах
- Ашиг сонирхол бүхий бүлгүүдээс ямар асуудлаар байр суурийг нь сонсох гэж байгаа
- Ашиг сонирхол бүхий бүлгүүд саналаа ямар журмаар, ямар хугацаанд өгөх талаар тодорхойлох
- Төслийг болосвруулах дараагийн ажиллагаанууд болон олон нийтийн зүгээс ямар оролцоотой байхыг тодорхойлох зэрэг орно.

4.6. Хэлэлцүүлэг зөвлөлдөөнд оролцож байгаа талууд өөрсдийн саналыг тодорхой хугацаанд өгнө. Олон нийтийн хэлэлцүүлэг зөвлөлдөөн нь 4 долоо хоногийн турш үргэлжилнэ. Тодорхой тохиолдолуудад хэлэлцүүлэг зөвлөлдөөний хугацааг дээрх тогтоосон хугацаанаас багаар тогтоож болно. Тодорхой тохиолдолуудад эсхүл төслийн хэмжээ, агуулгаас хамаарч олон нийтийн хэлэлцүүлэг зөвлөлдөөний хугацааг тогтоосон хугацаанаас их хугацаагаар тогтоож болно.

5. Олон нийттэй зөвлөлдөөн хэлэлцүүлэг явуулах мэдээллийн сувгууд

Олон нийт болон ашиг сонирхолын бүлгүүдээс санал авч, зөвлөлдөхийн тулд илгээсэн баримт бичигт нэвтрэх боломж байгаа эсэхийг харгалзан үзсэний үндсэн дээр мэдээллийн сувгуудыг сонгох ёстой.

6. Санал авах болон хэлэлцүүлэг зөвлөлдөөний үр дүнгийн талаар мэдэгдэх

6.1. Ашиг сонирхол бүхий бүлэглэлүүд нь оновчтой тодорхой цаг хугацааны дотор буюу зөвлөлдөх хугацааны төгсгөлөөс тухайлбал 30 хоногийн дотор саналаа өгөх ёстой. Хэрэв зөвлөлдөх хугацаа нь 3 сараас илүү хугацаагаар үргэлжилбэл эсхүл өөр өөр шатанд хийгдвэл эрх бүхий төрийн байгууллагаас хэлэлцүүлгийн үед гарсан саналыг нэгтгэх, саналын талаар товъёог бэлтгэх ба хэрэв хэлэлцүүлэг зөвлөлдөөн хийхээр товлосон хугацаанд өөрчлөлт оруулах шаардлагатай байгаа бол уг өөрчлөлтийн талаар уг хэлэлцүүлэг, зөвлөлдөөнд оролцох гэж байсан ашиг сонирхолын бүлгүүдэд энэ талаар мэдээлнэ.

6.2. Ашиг сонирхол бүхий бүлэглэлүүдтэй хийсэн зөвлөлдөөний үр дүнгийн талаар шийдвэр гаргагчдад мэдэгдэх ёстой. Зөвлөлдөөний үр дүнг нэгтгэн саналын товъёог бэлтгэх ажлыг эрх бүхий төрийн байгууллага хариуцна. Саналын товъёогт зөвлөлдөөн хэлэлцүүлэгт оролцсон ашиг сонирхолын бүлгүүдийн илэрхийлсэн санаа, өгсөн санал, хийсэн тэмдэглэлийг тусгаж, саналын

үндэслэлийг тодруулна. Хэрэв шийдвэр гаргагч саналыг хүлээж аваагүй бол үндэслэл, тайлбараа бичиж тодруулна.

- 6.3. Шийдвэрийг гаргахдаа дүгнэлтийг мөн хавсаргаж энэ хуулийн 6.1-д тодорхойлсон санал өгсөн ашиг сонирхолын бүх бүлгүүдэд илгээнэ. Хэрэв саналын талаарх дүн шинжилгээ шаардлагатай байх онцгой тохиолдолд 30 хоногоос их хугацаа тогтоож саналын анализийг ирүүлэх эцсийн хугацааг ашиг сонирхол бүхий бүлгүүдэд мэдэгдэнэ. Дүгнэлтийг Хуулийн төслийн Мэдээллийн Системд хэвлэн нийтэлж боловсруулж буй төсөлтэй зэрэгцүүлэн байрлуулна эсхүл бүх ажиллагаа хийгдэж дууссаны дараа нэвтрэх боломжтой байхаар байршуулна.

7. Үнэлгээ

- 7.1. Чухал ач холбогдол бүхий төслүүдий талаар олон нийттэй зөвлөлдөн, хэлэлцүүлэг хийсний эцэст төрийн эрх бүхий байгууллага нь оролцооны байдлаар дүгнэлт хийхдээ зорилгодоо хүрсэн эсэх, хэрэглэсэн арга хэрэгсэл хир холбогдолтой байсан эсэх, хэлэлцүүлэг зөвлөлгөөнд оролцсон ашиг сонирхол бүхий бүлгүүд хир оролцоотой байсан эсэх, тэдгээрийн өгсөн саналын үр нөлөө, хэлэлцүүлэгт оролцсон ашиг сонирхолын бүлгүүд хир сэтгэл ханамжтай байсан эсэх зэргийг харгалзана. Тус зорилгын үүднээс эрх бүхий төрийн байгууллага ашиг сонирхолын бүлгүүдийн оролцооны талаар үнэлгээ хийлгэж болно.
- 7.2. Үнэлгээний үр дүнг дараагийн удаа олон нийтийн оролцоог төлөвлөж, зохион байгуулхад ашиглаж болно.